

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Олон Улсын Дунд Сургуулиас та бүхэнтэй дахин мэндчилж мэдээгээ бичиж байгаадаа баяртай байна. Би гадагшаа явж багш сонгон шалгаруулах хуралд оролцоод ирлээ. Одоогийн байдлаар ирэх хичээлийн жилд ажиллах 11 багшаас 9 багшийг сонгон шалгаруулж ажилд аваад байна. Манай сургуулиас таван багш энэ хичээлийн жил дуусгаад буцна. Бид хөтөлбөрөө өргөжүүлж нэг ангид ногдох сурагчдын тоог цөөлөх учраас нэмж хэдэн багш нар ажилд авч байна.

Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагандаа манай ОУДС-ийн хамт олон бид нухацтай анхаардаг. Саяхан манай сурагчид зуданд нэрвэгдсэн малчдад туслах зорилгоор 28 хайрцаг тусламжийн бараа, хүнсний зүйл, дулаан хувцас цуглуулж Ховд аймгийн Булган сум руу ачууллаа. Энэ арга хэмжээг манай 4-р ангийн сурагчид санаачлан зохион байгуулсан нь манай сурагчдын нийгэмд хандсан үйлчлэлийн дүр төрхийг тодорхой харуулж байгаа юм. Бидэнд үйлчлэлийн олон боломжуудыг олгож байдаг амьдарч буй орчингоо бид сайн мэдэрч цаг тухайд нь нийгэмд үйлчлэх нь ИВ сургуулийн хувьд хамгийн чухал үзүүлэлт байдаг.

Энэ хичээлийн жилд бид нийгэмд үйлчилсэн олон арга хэмжээ зохион байгуулсанаас заримыг нь дурдвал:

- 5-р ангийн сурагчид маань Цэцэглэх Ирээдүй төвд ногоон хүлэмж барих болон гэр хороололын айлуудын гэрийн бүрээсийг солих санхүүжилтийг өөрсдийн хандиваар цуглуулсан
- Шинэ оны өмнө сүлд модны дор бэлэг цуглуулах арга хэмжээ зохион байгуулж цуглуулсан бэлгээ Fraternity of Notre Dame хүүхдийн төвд болон Солонго хүүхдийн төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд гардуулж өгсөн
- Олон Улсын Хатагтай нарын нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжин ариун цэврийн жижиг бүтээгдэхүүн цуглуулж хандивласан
- Соёл Урлагийн Их Сургуулийн нэг оюутаны сургалтын төлбөрийг сурагчдын цуглуулсан хандивын мөнгөөр санхүүжүүлсэн
- АНУ-ын Marine Corps-той хамтран Багачуудад Тоглоом Бэлэглэе арга хэмжээнд оролцож тоглоом хүнсний зүйлс цуглуулан Verbist асрамжийн төвд хандивласан.

ОУДС-иас зохиодог нийгэмд үйлчлэх олон төрлийн арга хэмжээг байнга дэмжиж байдаг та бүхэнд баярлалаа. Бусдад тусламжийн гараа сунгаж байдаг сурагчдаараа бид байнга бахархаж байдаг юм.

**Захирал Greg Rayl**

## **ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:**

3 сарын 3	10-р ангийн сурагчдын бие даасан ажлын тайлан хамгаалалт
3 сарын 5	Бага Сургуулийн сурагчид кино үзнэ
3 сарын 18	Бага Сургуулийн Сурагчдын Жүжигчилсэн Тоглолт

## **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Цагаан Сарын дараа хавар ирнэ гэж бид бодож байтал эргээд хүйтэрлээ. Та бүхэн өглөө хүүхдээ хичээлдээ явахаас нь өмнө цаг агаар ямар байхыг шалгаж байгаарай. Учир нь олон сурагчид нимгэн хувцастай куртка, малгай, ороолтгүй хичээлдээ ирж байна. Хэдийгээр нартай ч гэсэн агаарын температур нэлээд хүйтэн байна.

Дунд Сургуулийн сурагчдын сургууль дээр хонох арга хэмжээ амжилттай болж өнгөрлөө. Амралтын өдрөөрөө Бүтэн Сайны өглөө эрт 8:00-д хүүхдүүдээ цагт нь ирж авсанд та бүхэнд баярлалаа.

Амралтын өдрүүдэд би гадагшаа явж сургалтанд сууж Азийн бусад олон улсын дунд сургуулиудын удирдлагууд болон багш нартай уулзаж тэд бидний нэгэн адил сурагчиддаа хамгийн шилдэг боловсрол олгохын төлөө юу хийж байгаа талаар санал солилцлоо. Бид өөрсдийгөө бүсийн бусад

сургуулиудтай харьцуулж ОУДС-ийн хамт олон бид сайн ажиллаж байгаа гэдгээ мэдэж авахад таатай байлаа. Манай багш нарын таны хүүхдүүдийн төлөө хийж байгаа ажлыг магтах хэрэгтэй. Монголд сурагчиддаа шилдэг боловсрол эзэмшүүлж байгаа багш нартаа талархал илэрхийлье!

**Дунд Сургуулийн Эрхлэгч  
Betsy Hanselmann**

### 10-р ангийн сурагчдын Бие Дааж Гүйцэтгэсэн Төслийн Тайлан Хамгаалалт

3 сарын 3-ны Лхагва гарагт 10-р ангийн сурагчдын бие дааж гүйцэтгэсэн төслийн тайлан хамгаалалт болно. Энэ үеэр 10-р ангийн сурагчид өөрсдийн хийсэн бүтээлээ эцэг эхчүүдэд танилцуулж презентаци хийдэг. МҮР хөтөлбөрийн хүрээнд сурагчид өөрсдийн сонгосон сэдвээр бие даасан төсөл хийж гүйцэтгэдэг юм. Энэ жилийн 10-р ангийн сурагчид олон сэдвийн хүрээнд өөрсдийн төслийг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал:

- Үдэшлэгт өмсөх гоёлын платъег гаргасан загварын дагуу хэрхэн хийх
- Дүү нартаа зориулж амьдарч буй орчинтойгоо хэрхэн зөв харилцах талаар ном бичих
- Малти Медия хуанли хэрхэн зохиох гэх мэт.

Тайлан хамгаалалт орой 6 цагаас сургууль дээр эхэлж Монгол Хэлний анги болон Драммын ангид явагдана. Тайлан хамгаалалтын дараа эцэг эхчүүдэд хөнгөн зуушаар үйлчилнэ. 9 болон 10-р ангийн бүх сурагчдын эцэг эхчүүдийг энэ арга хэмжээнд оролцохыг урьж байна. Та бүхэнтэй Лхагва гарагт уулзацгаая.

**МҮР хөтөлбөрийн Зохицуулагч  
David Chilton**

### **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

**3 сарын 5-ны Баасан гарагт** Бага Сургуулийн сурагчид кино үзнэ. Хэрвээ хүүхэд тань кино үзэх бол та бүхэн зөвшөөрлийн хуудсыг бөглөөд 3 сарын 2-ны Мягмар гарагт сургуульд буцааж ирүүлнэ үү. Сурагчдын Зөвлөл Мягмар гарагийн үдээс хойш хуралдаж кино үзэх хүүхдийн тооноос хамаарч өрөөний болон бусад зохицуулалтыг хийх болно.

### **3 сарын 18 - ны Пүрэв Гараг-Charlie and the Chocolate Factory**

Манай тоглолт болох хугацаа ойртсоор л байна. Үлдсэн хугацаанд бид жүжгийн бэлтгэлээ шаргуу хийх тул сурагчид хичээлдээ тогтмол явах нь чухал байна. Сурагчид сайн унтаж амарч, ус сайн ууж, гараа тогтмол угааж өвдөхгүй байх хэрэгтэй.

Тоглолт болох өдөр бэлтгэл ангиас тавдугаар ангийн бүх сурагчид оройн 6 цаг гэхэд сургууль дээр буцаж ирсэн байх ёстой. Тоглолт 7 цагт эхлэхээс өмнө эцэг эхчүүд, зочдод зориулсан жигнэмэгийн худалдаа явагдана. Жүжгийн бэлтгэлд тусалж байгаа бүх эцэг эхчүүддээ баярлалаа. Эцэг эхчүүд та бүхэн туслах хүсэлтэй бол өдөр бүр 8:30-4:00 цагийн хооронд ирж тусалж болно. Зургийн ангийн хажуу өрөөнд жүжгийн бэлтгэл ажил явагдаж байгаа бөгөөд та бүхэн завтай бол өдөрт нэг, хоёр цагаар ирж тусалж болно.

Хувцас оёх ажлыг дуусгахад бидэнд тусламж хэрэгтэй байгаа бөгөөд та бүхэн туслах боломжтой бол бэлтгэл ангийн туслах багш Оюунгэрэл, Цацрал нартай уулзаж зааварчилгаа аваарай. Тоглолтын орой бидэнд бас видеокамераар бичлэг хийж зураг авах мэргэжлийн зурагчин хэрэгтэй байна. Хэрвээ та бүхэн энэ ажлыг хийж чадах бол эсвэл мэргэжлийн сайн зурагчин мэдэх бол Ms. Kim Carroll-тай холбоо бариарай.

**Бага Сургуулийн Эрхлэгч  
Jan Wiggins**

### **ОУДС зуданд нэрвэгдэгсэд тусламж үзүүлээ**

2 сарын 19-ны Баасан гарагт НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2 машинд манай сурагчид хорин найман ширхэг хайрцаг тусламжийн бараа ачиж зуданд нэрвэгдсэн Ховд аймгийн Булган сумын сургуульд хүргүүлэхээр боллоо.

4-р ангийн сурагчид нүүдэлчдийн амьдралын талаар судалж байхдаа хөдөө аймгуудаар зуд болж өвөлжилт хүндэрч байгаа талаар сонсоод зуданд нэрвэгдэгсдэд туслах хөдөлгөөнийг нийт сургууль даяар өрнүүлсэн.

Нийт сургуулийн өдөрлөгийн үеэр 4-р ангийн сурагчид сургуулийнхаа нийт сурагчдыг зуданд нэрвэгдсэн малчдад туслахыг уриалсан юм. Арав гаруй хоногийн хугацаанд тэд лаа, шүдэнз, элсэн чихэр, гурил, будаа, хуурай сүү, бүтээлэг, гар нүүрийн алчуур, дулаан хувцас зэрэг тусламжийн бараа цуглуулж нийт 28 хайрцаг барааг Улаанбаатараас 2000 км зайд орших Ховд аймгийн Булган суманд хүргүүлэхээр НҮБ-ын Хүүхдийн Сангийн ажилтнуудад хүлээлгэж өглөө. Сурагчид зуданд нэрвэгдсэн малчдын ар гэрийхэнд сэтгэлийн үгээ бичсэн ил захидлуудыг хамт илгээсэн.

Малчдад хандив өгсөн сургуулийнхаа нийт сурагчдад болон тэдний гэр бүлийхэнд талархал илэрхийлье!

**4-р ангийн Хамт олон, багш Mrs. D'Souza, Ms. Faber, Ms. Ариунжаргал**